**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэврэй сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2024/07/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Даланзадгад хот<br>2024 он | Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: С.Одончимэг<br>Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn<br>Аудитор: Э.Жаргал<br>Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.02.23 № 87

танай ______________-ны №______________ -т

СЭВРЭЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Ш.ОДМАА
ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэврэй сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэврэй сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, бараа материалын тооллого хийгээгүй, төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрүүтэй бүртгэсэн 37,605.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 51,791,184.4 мянган төгрөгийн 30 км авто замыг бүртгэлд тусгасан байна.

### Аудитын гол асуудал

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 74,881.8 мянган төгрөг, сумын төсвийн орон

0160201З6

F:\2.Бичиг хэрэг 2024он\СТА-н дүгнэлт\Тосол.Docx

хөрөнгө оруулалтаар 41,475.0 мянган төгрөгийн гудамжны гэрэлтүүлэгийн ажил хийгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 37 зорилтын хүрээнд 124 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 96.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2024он\СТА-н дүгнэлт\Тосол.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **252,057,832.97** | **440,006,485.97** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **3121** | **Төгрөг** | - | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | - |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | - |
| **33** | **АВЛАГА** | 34,169,000.00 | 28,314,376.00 |
| **335** | **Бусад авлага** | 34,169,000.00 | 28,314,376.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 31,734,000.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,435,000.00 | 28,314,376.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 170,864,332.97 | 323,926,309.97 |
| **351** | **Түүхий эд материал** | 34,500,000.00 | 34,500,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 34,500,000.00 | 34,500,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 136,364,332.97 | 289,426,309.97 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,603,350.00 | 3,519,650.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,264,400.00 | 7,850,200.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 7,050,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 2,039,300.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 118,496,582.97 | 268,967,159.97 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 47,024,500.00 | 87,765,800.00 |
| 36300 | Тэжээлийн нөөц | 47,024,500.00 | 87,765,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,986,988,974.47** | **63,513,612,554.86** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 10,986,988,974.47 | 63,513,612,554.86 |
| **392** | **Биет хөрөнгө** | 10,795,864,607.94 | 63,321,864,854.86 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,710,278,186.02 | 1,875,578,186.02 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (184,099,919.90) | (235,402,800.38) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 311,285,500.00 | 182,368,900.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (108,470,763.46) | (90,922,932.92) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 273,964,783.10 | 413,092,422.10 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (125,498,200.93) | (140,918,909.89) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 145,413,035.40 | 166,815,850.60 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (36,165,325.50) | (48,151,411.73) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 7,128,465,906.00 | 58,227,600,332.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (24,692,428.58) | (147,100,185.38) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2,241,080,689.70 | 3,799,851,452.70 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (535,696,853.91) | (680,946,048.26) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 191,124,366.53 | 191,747,700.00 |
| 39301 | Програм хангамж | 6,950,000.00 | 2,025,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (6,380,833.47) | (832,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 190,555,200.00 | 190,555,200.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **11,239,046,807.44** | **63,953,619,040.83** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **4,075,971.28** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 4,075,971.28 |
| **413** | **Өглөг** | - | 4,075,971.28 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 4,075,971.28 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **11,239,046,807.44** | **63,768,885,319.55** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 11,239,046,807.44 | 63,768,885,319.55 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 546,608,112.56 | 546,608,112.56 |
| 51101 | Өмч: - төрийн | 546,608,112.56 | 546,608,112.56 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 10,498,463,427.25 | 63,028,301,939.36 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 10,498,463,427.25 | 10,498,463,427.25 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 52,529,838,512.11 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 193,975,267.63 | 193,975,267.63 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **11,239,046,807.44** | **63,772,961,290.83** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,801,320,559.00** | **3,960,957,376.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **27,937,185.00** | **67,641,650.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 27,937,185.00 | 67,641,650.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 27,937,185.00 | 66,941,650.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 243,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 27,937,185.00 | 66,698,650.00 |
| 120009 | Бусад орлого | - | 700,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,773,383,374.00** | **3,893,315,726.90** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,103,728,874.00 | 2,951,145,826.90 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,022,110,792.00 | 2,942,553,771.90 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 70,837,369.00 | 5,987,055.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 10,780,713.00 | 2,605,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 669,654,500.00 | 942,169,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөв/ | 669,654,500.00 | 942,169,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,885,254,173.13** | **4,478,103,083.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,885,254,173.13** | **4,478,103,083.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,829,215,896.11 | 4,198,653,711.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 235,761,186.00 | 380,220,081.56 |
| 210101 | Үндсэн цалин | 162,177,147.18 | 230,184,980.22 |
| 210102 | Нэмэгдэл | 41,806,999.42 | 116,906,901.34 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,567,468.60 | 25,753,000.00 |
| 210104 | Урамшуулал | 5,209,570.80 | 7,375,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,225,453.98 | 47,701,997.26 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,995,129.35 | 33,119,497.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,373,763.95 | 2,782,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,855,435.41 | 3,637,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 415,670.35 | 687,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,585,454.92 | 7,475,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,558,212.00 | 41,532,075.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,799,343.60 | 11,497,200.00 |
| 210302 | Түлш, халаалт | 22,798,868.40 | 29,064,875.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 960,000.00 | 970,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 92,225,478.02 | 71,219,660.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 12,262,910.00 | 12,780,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 41,373,059.00 | 38,690,485.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,278,000.00 | 5,998,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,111,509.02 | 7,749,475.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,200,000.00 | - |
| **2105** | **Норматив зардал** | 4,512,000.00 | 1,606,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,512,000.00 | 1,606,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 28,901,500.00 | 39,528,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 28,901,500.00 | 39,528,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,413,975.00 | 10,296,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,413,975.00 | 10,296,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 79,820,771.00 | 225,212,324.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 69,820,771.00 | 225,212,324.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,000,000.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,322,797,320.11 | 3,381,336,573.05 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,034,595,990.00 | 2,911,819,456.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,100,000.00 | 7,437,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 287,101,330.11 | 462,079,616.65 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 56,038,277.02 | 279,449,372.56 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,396,119.00 | 103,393,662.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 26,104,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 19,396,119.00 | 77,289,462.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 35,525,382.16 | 128,692,156.64 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,525,382.16 | 128,692,156.64 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,116,775.86 | 47,363,553.92 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,116,775.86 | 47,363,553.92 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(83,933,614.13)** | **(517,145,706.93)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 896,264.29 | 172,357,477.96 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 896,264.29 | 96,839,999.96 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | - | 75,517,478.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (896,264.29) | (172,357,477.96) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(84,829,878.42)** | **(689,503,184.89)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,818,138,374.00** | **4,104,210,690.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **44,755,000.00** | **210,894,964.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 44,755,000.00 | 210,894,964.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 44,755,000.00 | 210,894,964.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 44,755,000.00 | 210,894,964.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,773,383,374.00** | **3,893,315,726.90** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,103,728,874.00 | 2,951,145,826.90 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,022,110,792.00 | 2,942,553,771.90 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 70,837,369.00 | 5,987,055.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 10,780,713.00 | 2,605,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 669,654,500.00 | 942,169,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 669,654,500.00 | 942,169,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,651,317,374.00** | **3,657,833,500.90** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,651,317,374.00** | **3,657,833,500.90** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,595,279,096.98** | **3,378,384,128.34** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 235,761,186.00 | 371,038,507.54 |
| 210101 | Үндсэн цалин | 162,177,147.18 | 221,809,607.54 |
| 210102 | Нэмэгдэл | 41,806,999.42 | 116,660,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 26,567,468.60 | 25,193,000.00 |
| 210104 | Урамшуулал | 5,209,570.80 | 7,375,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,225,453.98 | 51,007,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,995,129.35 | 36,425,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,373,763.95 | 2,782,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,855,435.41 | 3,637,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 415,670.35 | 687,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,585,454.92 | 7,475,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 30,558,212.00 | 41,532,075.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,799,343.60 | 11,497,200.00 |
| 210302 | Түлш, халаалт | 22,798,868.40 | 29,064,875.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 960,000.00 | 970,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 64,110,419.00 | 66,589,655.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,099,950.00 | 8,662,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,450,969.00 | 40,316,785.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,360,000.00 | 6,340,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 200,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,999,500.00 | 5,270,370.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5,112,800.00 | 1,606,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,512,000.00 | 1,606,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 600,800.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 16,468,100.00 | 35,152,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 4,630,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,468,100.00 | 30,522,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,413,975.00 | 10,296,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,413,975.00 | 10,296,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 61,177,665.00 | 231,088,932.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 61,177,665.00 | 231,088,932.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,147,451,286.00 | 2,570,072,958.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,146,351,286.00 | 2,562,667,958.40 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,100,000.00 | 7,405,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **56,038,277.02** | **279,449,372.56** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 19,396,119.00 | 103,393,662.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 26,104,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 19,396,119.00 | 77,289,462.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 35,525,382.16 | 128,692,156.64 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,525,382.16 | 128,692,156.64 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,116,775.86 | 47,363,553.92 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,116,775.86 | 47,363,553.92 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **166,821,000.00** | **446,377,190.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **166,821,000.00** | **446,377,190.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **166,821,000.00** | **446,377,190.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 166,821,000.00 | 446,377,190.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 46,276,000.00 | 446,377,190.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 120,545,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(166,821,000.00)** | **(446,377,190.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 419,689,732.56 | 193,975,267.63 | 2,582,732,089.67 | 3,196,397,089.86 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **419,689,732.56** | **193,975,267.63** | **2,582,732,089.67** | 3,196,397,089.86 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 126,918,380.00 | - | - | 126,918,380.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 7,915,731,337.58 | 7,915,731,337.58 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **546,608,112.56** | **193,975,267.63** | **10,498,463,427.25** | 11,239,046,807.44 |
| **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **546,608,112.56** | **193,975,267.63** | **10,498,463,427.25** | 11,239,046,807.44 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **546,608,112.56** | **193,975,267.63** | **10,498,463,427.25** | 11,239,046,807.44 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 52,529,838,512.11 | 52,529,838,512.11 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **546,608,112.56** | **193,975,267.63** | **63,028,301,939.36** | 63,768,885,319.55 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Тайлант оны гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,116,940,900.00 | 1,024,372,707.36 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 877,675,100.00 | 817,793,335.36 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 838,070,900.00 | 779,018,997.36 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 356,051,200.00 | 356,051,199.96 |
| 210101 | Үндсэн цалин | 206,822,300.00 | 206,822,299.96 |
| 210102 | Нэмэгдэл | 116,660,700.00 | 116,660,700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 25,193,000.00 | 25,193,000.00 |
| 210104 | Урамшуулал | 7,375,200.00 | 7,375,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,007,600.00 | 51,007,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,425,100.00 | 36,425,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,782,400.00 | 2,782,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,637,400.00 | 3,637,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 687,500.00 | 687,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,475,200.00 | 7,475,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 42,103,200.00 | 41,532,075.40 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,497,200.00 | 11,497,200.00 |
| 210302 | Түлш, халаалт | 29,636,000.00 | 29,064,875.40 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 970,000.00 | 970,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 61,307,600.00 | 60,761,470.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,896,500.00 | 8,517,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 34,800,000.00 | 34,633,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,340,000.00 | 6,340,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,271,100.00 | 5,270,370.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,221,100.00 | 20,211,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,630,000.00 | 4,630,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,591,100.00 | 15,581,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,000,000.00 | 9,816,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,000,000.00 | 9,816,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 115,204,200.00 | 114,151,792.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 115,204,200.00 | 114,151,792.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 182,176,000.00 | 125,487,860.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 174,771,000.00 | 118,082,860.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,405,000.00 | 7,405,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 39,604,200.00 | 38,774,338.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 39,604,200.00 | 38,774,338.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,104,200.00 | 26,104,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,500,000.00 | 12,670,138.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **239,265,800.00** | **206,579,372.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 239,265,800.00 | 206,579,372.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 239,265,800.00 | 206,579,372.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,116,940,900.00 | 1,024,372,707.36 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,116,940,900.00 | 813,477,743.36 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,116,940,900.00 | 813,477,743.36 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 210,894,964.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 210,894,964.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **-** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,903,782,272.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,663,984,454.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,599,365,130.98 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 14,987,307.58 |
| 210101 | Үндсэн цалин | 14,987,307.58 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,828,185.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 145,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,683,185.00 |
| **2105** | **Норматив зардал** | 1,606,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1,606,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 14,941,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,941,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 480,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 480,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 116,937,140.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 116,937,140.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,444,585,098.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,444,585,098.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 64,619,324.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 64,619,324.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 64,619,324.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **47,363,553.92** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 47,363,553.92 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **239,797,818.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 239,797,818.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 239,797,818.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,951,145,826.90 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,951,145,826.90 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,942,553,771.90 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,987,055.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,605,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 35,932.09 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 35,932.09 мянган төгрөгийн алдааг залруулж ажилласан. Үүнд:

- Санхүү байдлын тайлангийн авлагын нийт дүнг авлагын тодруулга тайлангийн авлагын эцсийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад 174.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 1,260.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан,

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглэлгүй орхисон/,

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдаж авсан хөрөнгийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалтай тулган баталгаажуулахад 4,630.0 мянган дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 1,260.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн шуудан холбоо, интернэтийн төлбөр зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 398.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн гэрэл цахилгааны зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 509.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Тайлант онд 4,075.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагыг бүртгэлд тусгаагүй тайлагнасан,
- Тайлант хугацаанд 19,980.0 мянган төгрөгийн 10 айл орон сууцны барилгын зураг төсвийг бүртгэлд тусгаагүй,
- Тайлант хугацаанд 3,643.8 мянган төгрөгийн худалдан авсан шатахууныг шууд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан байна.

Аудитаар нийт 37,767.3 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 5,043.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,265.1 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлэв.

**3.1 Төлбөрийн акт**

***Илрүүлэлт*:1** Тайлант хугацаанд 13 албан хаагчид хоолны хөнгөлөлт олгохдоо албан томилолтоор ажилласан хугацааны нөхөх төлбөрийг хасаж тооцоогүй давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "*үнэн зөв байх*", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 *”төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*-д заасантай тус тус нийцэхгүй байна.

***Илрүүлэлт*:2** Тайлант хугацаанд 2,500.0 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт олгохдоо төвийн дулаанд холбогдсон айл өрхөд олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Засгийн газрын 2021 оны 6 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам"-ын 8 дугаар зүйлийн 8.3 "*Ердийн галлагаатай сууцанд амьдардаг төрийн албан хаагчид өвлийн улирлын түлш худалдан авах зардлын зохих хэсгийг байгууллагаас нөхөн олгож болно*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

***Илрүүлэлт*:3** Тайлант хугацаанд 1,920.0 мянган төгрөгийн бэлэг худалдан авч албан хаагчдын хүүхдүүдэд тараасан байна.

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.7 “*Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно*", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 "*төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**3.2 Албан шаардлага**

***<u>Илрүүлэлт</u>:1*** Тайлант хугацаанд нягтлан бодогч нь 22,297.5 мянган төгрөгийн тээвэр шатахуун зарцуулсан боловч зарцуулалтын тооцоо бодоогүй, жолоочийн тооцооны хуудсыг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "*үнэн зөв байх*", Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Жишиг норм батлах тухай" 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заасантай тус тус нийцэхгүй байна.

***<u>Илрүүлэлт</u>:2*** Байгууллагын эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогын бүртгэлийг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "*үнэн зөв байх*", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 4 "*Тооллогын комисс дараах үүрэгтэй*", 4.1 "*эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах*"-д гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

***<u>Илрүүлэлт</u>:3*** Тайлант онд бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 1,385.1 мянган төгрөгөөр цонхны шил, цоож зэрэг зүйлс худалдан авч төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

***<u>Илрүүлэлт: 4</u>*** Шилэн дансны нэгдсэн системд дараа жилийн төсвийн төсөл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээлэл, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 *"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ",* 6.1.3 *"дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор",* 6.1.5 "*төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор*", 6.1.6 *"төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр",* 6.4.7 *"байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь</u>**: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "*Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын*

*байгууллагад хариу мэдэгдэнэ*" гэсэн заалтыг үндэслэн төсвийн шууд захирагчид сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага.

### 3.3 Зөвлөмж

Аудитаар өгөгдсөн зөвлөмж байхгүй.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг хангаж Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт  2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүү байдлын тайлангийн авлагын нийт дүнг авлагын тодруулга тайлангийн авлагын эцсийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад 174.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 174.00 | | | 1 | 174.00 | 1 | 174.00 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 1,260.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан | 1 | 1,260.00 | | | 1 | 1,260.00 | 1 | 1,260.00 | | | | |
| Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдаж авсан хөрөнгийн дүнг мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалтай тулган баталгаажуулахад 4,630.0 мянган дутуу тайлагнасан | 1 | 4,630.00 | | | 1 | 4,630.00 | 1 | 4,630.00 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 1,260.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 1,260.00 | | | 1 | 1,260.00 | 1 | 1,260.00 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн шуудан холбоо, интернэтийн төлбөр зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 398.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 398.80 | | | 1 | 398.80 | 1 | 398.80 | | | | |
| Мөнгөн гүйлгээний тайлангийн гэрэл цахилгааны зардлын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 509.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан | 1 | 509.42 | | | 1 | 509.42 | 1 | 509.42 | | | | |
| Тайлант онд 4,075.9 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагыг бүртгэлд тусгаагүй тайлагнасан | 1 | 4,075.97 | | | 1 | 4,075.97 | 1 | 4,075.97 | | | | |
| Тайлант хугацаанд 19,980.0 мянган төгрөгийн 10 айл орон сууцны барилгын зураг төсвийг бүртгэлд тусгаагүй | 1 | 19,980.00 | | | 1 | 19,980.00 | 1 | 19,980.00 | | | | |
| Тайлант хугацаанд 3,643.8 мянган төгрөгийн худалдан авсан шатахууныг шууд зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан | 1 | 3,643.90 | | | 1 | 3,643.90 | 1 | 3,643.90 | | | | |
| **Дүн** | **7** | **35,932.09** | | | **7** | **35,932.09** | **7** | **35,932.09** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд нягтлан бодогч нь тээвэр шатахуун зарцуулсан боловч зарцуулалтын тооцоо бодоогүй, жолоочийн тооцооны хуудсыг баталгаажуулаагүй | 1 | 22,297.54 | | | 1 | 22,297.54 | | | | | | |
| Тээвэр шатахууны зардлын зарцуулалтын нормыг давтан тооцоолж үзэхэд илүү зарцуулсан байна. | 1 | 161.73 | | | 1 | 161.73 | | | | | | |
| Байгууллагын эд хөрөнгийн жилийн эцсийн тооллогын бүртгэлийг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган баталгаажуулахад зөрүүтэй байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Тайлант онд бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас цонхны шил, цоож зэрэг зүйлс худалдан авч төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 1,385.10 | | | | | | | | | | |
| Тайлант хугацаанд 13 албан хаагчид хоолны хөнгөлөлт олгохдоо албан томилолтоор ажилласан хугацааны нөхөх төлбөрийг хасаж тооцоогүй байна. | 1 | 623.00 | 1.00 | 623.00 | | | | | | | | |
| Тайлант хугацаанд хэвлэл захиалгын төлбөр төлсөн. | 1 | 8,880.00 | | | | | | | 1 | 1 | | |
| Тайлант хугацаанд түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо төвийн дулаанд холбогдсон айл өрхөд олгосон байна. | 1 | 2,500.00 | 1.00 | 2,500.00 | | | | | | | | |
| **Дүн** | **7** | **35,847.37** | **2** | **3,123.00** | **3** | **22,459.27** | **-** | **-** | **1** | **1** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн системд дараа жилийн төсвийн төсөл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээлэл, аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг байршуулаагүй байна. | 1 | | | | 1 | | | |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **-** | **-** |
| **Бусад хууль, тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Тайлант хугацаанд 1,920.0 мянган төгрөгийн бэлэг худалдан авч албан хаагчдын хүүхдүүдэд тараасан | 1 | 1,920.00 | 1 | 1,920.00 | | | | |
| **Дүн** | **1** | **-** | **1** | **1,920.00** | **-** | **-** | **-** | **-** |
| **Нийт дүн** | **2** | **1,920.00** | **1** | **1,920.00** | **1** | **-** | **-** | **-** |